



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 09 сарын 07 өдөр

Дугаар A/133

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Тарвасны орчмын талбайн тохижилт /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Д.Ариунбилэг -Хяналт -шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүдэд: Б.Даваасүрэн - Жаргалант сумын эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн

Ц.Пүрэвзул -Төрийн бус байгууллагын төлөөлөл

Ж.Пүрэв-Очир -Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Э.Цолмон -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Д.Ариунбилэг/-д даалгасугай.

3.Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД